

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2017 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-  
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

2018.03.20

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН  
ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ**

2018.03.20

## **1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Дархан-Уул аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон УИХ-ын байнгын хорооны 2 тогтоолын 3 заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 4 заалт, УАБЗ – ийн 2 зөвлөмжийн 3 заалт, Засгийн газрын 54 тогтоолын 58 заалт, Засгийн газрын хуралдааны 16 тэмдэглэлийн 27 заалт, Засгийн газрын 1 албан даалгаврын 12 заалт, нийт 78 шийдвэрийн 107 заалтыг хяналтанд аван хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2017 оны жилийн эцсийн байдлаар **98.30 хувь буюу 4.91** онооны үнэлгээтэй байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд даргын 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ХЭГ/2004 албан бичгийн дагуу 2017 оны жилийн эцсийн байдлаар хугацаа дууссан 6, хүчингүй болсон 3, Төрийн захиргааны төв байгууллагат үүрэг болгосон-1, хөрөнгийн эх үүсвэргүй-1, бусад-1, нийт **12 шийдвэрийн 15 заалтыг** “хасах санал”-ыг аймгийн Засаг даргын орлогчийн 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 1-10/29 дүгээр албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн.

*Мэдээллийн хүртээмж:*

1. Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдийн албан хэрэгцээнд зориулж тайлангийн хэрэгжилт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулга, зөвлөмжийг төрийн байгууллагын Able cloud системийн “олон нийт” хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр байршуулж, “Мэдээллийн цаг”-аар мэдээлэл хийсэн.
2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлангийн хэрэгжилт, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, зөвлөмжийг 2018.01.15-ны өдөр танилцуулж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажилласан.
3. Аймгийн ИТХ-ын 33 Төлөөлөгчдийг мэдээллээр хангах зорилгоор цахим хаягаар нь 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдөр илгээсэн.
4. Аймгийн ИТХ-ын Засаг захиргаа, хууль эрх зүйн бодлого хяналтын хорооны бүрэлдэхүүнд 2018 оны 03 дугаар сарын 09-ны өдөр тус тус танилцуулсан.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд аймгийн Засаг даргын баталсан 24 заалт бүхий “Зөвлөмж”-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтэс болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын албан хаагчдад хүргүүлсэн. Зөвлөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл (**Хавсралт-1**-ийг үзнэ үү), “Зөвлөмж”-ийн тараасан бүртгэл (**Хавсралт-2**-ыг үзнэ үү)

*/Дэлгэрэнгүй тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд 2018.01.11-ны өдөр оруулж, аймгийн Засаг даргын орлогчийн 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 1-10/29 дүгээр албан бичгийн хавсралтаар ЗГХЭГ-ын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн/*

## **2. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn –ийн “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” цэсэнд байршсан 66 зорилтын 97 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үнэлгээ 2017 оны жилийн эцсийн байдлаар **96.13% буюу 4.80** онооны үнэлгээтэй байна.

*Мэдээллийн хүртээмж:*

1. Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдийн албан хэрэгцээнд зориулж тайлангийн хэрэгжилт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулга, зөвлөмжийг төрийн байгууллагын able cloud системийн “олон нийт” хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр байршуулж, аймгийн ЗДТГ-ын 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “Мэдээллийн цаг”-аар мэдээлэл хийсэн.
2. Аймгийн ИТХ-ын 33 төлөөлөгчдийг мэдэлэлээр хангах зорилгоор цахим хаягаар нь 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдөр илгээсэн.
3. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлангийн хэрэгжилт, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, зөвлөмжийг 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр танилцуулж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажилласан.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд аймгийн Засаг даргын баталсан 17 заалт бүхий “**Зөвлөмж**”-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтэс болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын албан хаагчдад хүргүүлсэн.

Зөвлөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл (**Хавсралт-3**-ыг үзнэ үү), Мэдээллийн хүртээмжийн баталгаажуулалт (**Хавсралт-4**-ийг үзнэ үү)

*/Дэлгэрэнгүй тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд 2018.01.31-ний өдөр оруулж, аймгийн Засаг даргын орлогчийн 2018.01.30-ны өдрийн 1-10/79 дүгээр албан бичгийн хавсралтаар ЗГХЭГ-ын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлж, цахим хэлбэрээр [nyambayar0101@gmail.com](mailto:nyambayar0101@gmail.com) хаягаар 2018.01.29-ны өдөр илгээв/*

### **3. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

Дархан-Уул аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хяналтанд авсан 2 зорилт, **39 арга хэмжээ**-ний нэгдсэн үнэлгээ **98.46%** буюу **4.92 оноо** буюу "**Үр дүнтэй**" гэж үнэлэгдлээ.

Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2017 оны оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 7 дахь удаагийн сонгуулийн ээлжит Есдүгээр хуралдаанаас "Хангалттай" гэж дүгнэсэн.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд 4 заалт бүхий "**Зөвлөмж**"-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсийн дарга нарын хуралдаанд сонсгол хэлбэрээр танилцуулсан.

Зөвлөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл (**Хавсралт-5**-ыг үзнэ үү)

/Дэлгэрэнгүй тайланг аймгийн Засаг даргын 2018.02.20-ны өдрийн 1-10/121 дүгээр албан бичгийн хавсралтаар ЗГХЭГ-ЫН газарт хүргүүлж, цахим хэлбэрээр [nyambayar0101@gmail.com](mailto:nyambayar0101@gmail.com) хаягаар 2018.02.20-ны өдөр илгээв/

#### **СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Дархан-Уул аймгийн Дархан сум, Шарын гол сум, Орхон сум, Хонгор сумдын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд сумын ЗДТГ-ЫН Хяналт-шинжилгээ, үнэлгээний багийн хийсэн үнэлгээг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан дүгнүүлж, хурлын шийдвэрийг гаргуулж ажилласан байна.

Сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дэлгэрэнгүй мэдээлэл (**Хавсралт-6**-г үзнэ үү)

2018.03.28-ны өдөр Дархан-Уул аймгийн Дархан сум, Шарын гол сум, Орхон сум, Хонгор сумдын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч (аймгийн 33 Төлөөлөгч)-ийн зөвлөгөөнд танилцуулсан болно.

#### **4. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2017-2020/, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 8 бүлэг, 139 зорилтыг хэрэгжүүлэх 307 арга хэмжээний хэрэгжилт 2017 оны жилийн эцсийн байдлаар **95.66%** буюу **4.78** онооны үнэлгээтэй байгааг аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн ээлжит есдүгээр хуралдаанаар “Хангалттай” гэж дүгнэсэн.

Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд аймгийн Засаг даргын баталсан 7 заалт бүхий “Зөвлөмж”-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтэс болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын албан хаагчдад хүргүүлсэн.

Зөвлөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл (**Хавсралт-7-г үзнэ үү**)

*/Дэлгэрэнгүй тайланг аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 1-10/104 дүгээр албан бичгийн хавсралтаар ЗГХЭГ-ын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн, цахим хэлбэрээр [damdinenkhbat164@gmail.com](mailto:damdinenkhbat164@gmail.com) хаягаар 2018.02.20-ны өдөр илгээв/*

## 5. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	2017 он		Үнэлгээ
		2016	Зорилтот түвшин	Бодит гүйцэтгэл	
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>					
1	<b>Дотоодын нийт бүтээгдэхүүн / сая ₮/</b>	386,883.5 <sup>1</sup>	395,148.8	389,863.1 <sup>2</sup>	100.0%
2	<b>Төсөв</b>				
	I. Төсвийн орлого бүрдүүлэлт /сая төг/	21200.0	19900.0	22000.0	100.0%
	II. Төсвийн хэмнэлт /хувь/	100.0	100.0	110.6	100.0%
3	<b>Сангийн эргэн төлөлт</b>				
	I. Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	100.0	100.0	100.0	100.0%
	II.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь	69.8	80.0	90.0	100.0%
4	<b>Хөдөлмөр эрхлэлт</b>				
	I. Ажилгүйдлийн түвшин	19.5	15.5	15.9	100.0%
	II. Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	1243	1200	1208	100.0%
5	<b>Хэрэглээний үнийн индекс</b>	102.2	102.1	104.9	100.0%
6	<b>Мал аж ахуй</b>				
	I. Малын тоон өсөлт	36.1	27.1	13.8 <sup>3</sup>	100.0%
	II. Эрчимжсэн аж ахуй	58	60	63	100.0%
	a.Аж ахуйн тоо	12.7	13.5	13.5	100.0%
	b. Малын тоо /мян. Тол/	3.7	4.3	4.5	100.0%
7	<b>Газар тариалан</b>				
	I. Хураан авсан үр тариа /мян.тн/	18.9	15.6	11.2	70.0%
	II. Хураан авсан малын тэжээл, бусад таримал /мян.тн/	1.7	1.2	2.35	100.0%
	III. Хураан авсан хүнсний ногоо /мян.тн/	14.4	12.8	20.5	100.0%
8	<b>Идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо</b>	803	824	915	100.0%
9	<b>Дэд бүтцэд холбогдсон орон сууцанд амьдарч буй иргэдийн хувь</b>	52.3	53.2	54.2	100.0%
10	<b>Шинэ санал, санаачилга боловсруулан хэрэгжүүлж, эдийн</b>	“Дархан-Уул аймагт 2017 онд хийгдсэн бүтээлч, шинэлэг ажлууд” <sup>4</sup>			100.0%

<sup>1</sup> 2016 оны дотоодын нийт бүтээгдэхүүний 386,883.5 <http://old.1212.mn/statHtml/statHtml.do>

<sup>2</sup> Хүлээгдэж буй гүйцэтгэлээр (Монгол Улсын Статистикийн эмхтгэл -2016 оны ДНБ- 378,562.9)

<sup>3</sup> Аймгийн бэлчээр нутгийн хэмжээ бага, бэлчээрийн даац 2 дахин хэтэрсэн, нийт малчдын 59.4 хувь нь гадны аймгийн сумын нутаг дэвсгэрт өвөлжиж хаварждаг, хүн амын хэрэгцээг тасралтгүй хангах зорилгоор мал аж ахуйг эрчимжүүлэх зэрэг шаардлагын улмаас боловсруулан хэрэгжүүлж буй “Дархан-Уул аймгийн Хөдөө аж ахуйн салбарыг 2021 онд хөгжүүлэх нэгдсэн бодлого”-д тусгагдсан малын тоог бэлчээрийн даацтай уялдуулан зохицуулах, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх сонирхлыг дэмжихи зорилттой нийцэж байгаа тул гүйцэтгэлийг үндсэн суурь үзүүлэлттэй харьцуулж бүрэн хангасан үнэлгээ өгсөн болно.

	<b>засаг, нийгмийн хөгжилд эзэрэг нөлөө үзүүлсэн байдал</b>				
<b>11</b>	<b>Иргэний шилжилт хөдөлгөөн цэвэр коэффициент =((Шилжиж ирсэн хүн амын тоо – Шилжиж явсан хүн амын тоо)/Аймгийн хүн амын тоо</b>	-9.1	-7.8	-4.2	100.0%
<b>12</b>	<b>Хүний хөгжил</b>				
	I. Хүний хөгжлийн индекс	0.715	0.720	0.707	100.0%
	II. Жендерийн тэгш бус байдлын индекс	0.818	0.819	0.811	100.0%
<b>13</b>	<b>Гэмт хэрэг</b>				
	I. Бүртгэгдсэн гэмт хэрэг (бууралтын хувь)	14.8	14.8	+13.8 <sup>5</sup>	үнэлэх боломжгүй
	II. Иргэдэд учирсан хохирлын нэхэн төлүүлэлтийн түвшин	58.3	60.0	28.7 <sup>6</sup>	40.0%
<b>14</b>	<b>Агаар дахь бохирдуулагч бодисын жилийн дундаж агууламжийн түвшин</b>				
	I. Азотын давхар исэл	0.020	0.019	0.019	100.0%
	II. Хүхэрлэг хий	0.010	0.009	0.009	100.0%
<b>15</b>	<b>Эрүүл мэнд</b>				
	I. Эрүүл мэнд (Эхийн эндэгдлийн түвшин)	40.2	0	0	100.0%
	II. Эрүүл мэнд (Нялхсын эндэгдлийн түвшин)	12.5	11.5	10.6	100.0%
	III. Халдварт өвчнөөр өвчлөгсөдийн түвшин	313.8	306.6	93.9	100.0%
<b>16</b>	<b>Боловсрол</b>				
	I. Цэцэрлэгт хамрагдалтын хувь	91.0	91.5	91.4	100.0%
	II. Сургуульд хамрагдалтын хувь	100.0	100.0	100.0	100.0%
	III. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалтын хувь	83.2	85.0	90.0	100.0%
	IV. Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	474.4	480	517.4	100.0%
	V. Шинээр ашиглалтад оруулсан цэцэрлэг, сургуулийн тоо (цэцэрлэг/сургууль)	1/0	1/0	1/1	100.0%
Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтээр 10 чиглэл, 18 шалгуур үзүүлэлт, нийгмийн үзүүлэлтээр 6 чиглэл, 15 шалгуур үзүүлэлт нийт 16 чиглэл, 33 шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн дундаж хувь <b>97.19%</b> буюу <b>4.86</b> оноо					

<sup>4</sup> “Дархан-Уул аймагт 2017 онд хийгдсэн бүтээлч, шинэлэг ажлууд”-ын дэлгэрэнгүй **Хавсралт 9-ыг** үзнэ үү.

<sup>5</sup> Хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан зөрчлийн шинжтэй үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй үйлдэлд хамаарч байгаагаас гэмт хэргийн өсөлт шалтгаалж байна.

<sup>6</sup> Аймгийн хэмжээнд Апу трейдинг ХХК-н Дархан-Уул аймаг дахь салбарт компанийн борлуултын мөнгөнөөс 405,000,000 төгрөгийг завшиж үрэгдүүлэн онц их хэмжээний хохирол учуруулсан хэрэг, Дархан сумын 8-р багт байрлах авто ломбарднаас 139.751.500 төгрөг запилсан эрүүгийн онц их хэмжээний хохиролтой хэргүүд гарч хохирлыг барагдуулаагүйгээс хохирол нэхэн төлөлтийн хувь буурсан дүнтэй байна.

Дархан-Уул аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг 16 чиглэл, 33 шалгуур үзүүлэлтээр гүйцэтгэлийг гаргаж үнэлэхэд **97.19%** буюу **4.86 онооны** үнэлгээтэй байна.

Үзүүлэлтийн дэлгэрэнгүй мэдээлэл **Хавсралт-8-ыг** үзнэ үү)

Улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээлийн хөрөнгө оруулалтаар 15,156.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 136 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувийн гүйцэтгэлтэй 1,249.5 сая төгрөгийн хэмнэлттэй, үр ашигтай, нээлттэй, ил тод хуулийн хүрээнд зохион байгуулсан.

Аж үйлдвэрийн салбарт 195.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 279.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, иргэдийн маань хувийн хадгаламж 179.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 35.4 тэрбум төгрөгөөр өссөн.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлтэй 1957 иргэдээс 1208 иргэнийг байнгын ажлын байранд зуучлан, 308 иргэнд өөрөө өөртөө ажлын байр бий болгоход нь зориулж 382.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 1093 иргэнийг түр ажлын байраар хангаж 214.1 сая төгрөгийг зарцууллаа.

Улсын төсвийн 1 тэрбум 340.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын 5-р багийн нутаг дэвсгэрт 100 хүүхдийн цэцэрлэгийг шинээр, 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Шарын гол сумын 2-р цэцэрлэгийн барилгын өргөтгөлийг барьж ашиглалтанд тус тус оруулсан. Хувийн хэвшлийн “Өсөх Сансар” ХХК нь өөрийн 1 тэрбум 30 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар орчин үеийн стандартын шаардлага хангасан 120-н хүүхдийн хүчин чадалтай “Өсөх Ирээдүй” цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулж, ясли, бага, дунд, ахлах, 24-н цагийн бүлэг, ихрүүдийн бүлгийг ажиллуулж, шинээр 20 ажлын байр бий болгосон. Анги дүүргэлт 100%. 2017 онд шинээр 560 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмжих нөхцөл бололцоогоор хангагдаж аймгийн хэмжээнд хамран сургалт 91.4%-тай байна.

2017 онд жирэмсэн эхчүүдийн эмнэлэгт хандах хандлага, жирэмсний болон төрөх, төрсний дараах үеийн тусламжийн чанарыг сайжруулснаар эхийн эндэгдэл гараагүй. Хүүхдийн өвчний цогц менежментийг хэрэгжүүлж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулснаар 1000 амьд төрөлтөнд ноогдох нярайн эндэгдлийг 6.6, нялхсын эндэгдлийг 10.6, 0-5 насны хүүхдийн эндэгдлийг 12.8 промил болгосон нь улсын дундаж үзүүлэлтээс 3.2-4.1 промилоор доогуур үзүүлэлттэй байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2017 онд 251 айлын орон сууц шинээр ашиглалтанд оруулсан.

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**БАЙГУУЛЛАГЫН ЧИГҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

**2018.03.20**

## 1. ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

2017 онд Монгол Улсын 15 сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт **98.40%** буюу **4.92 онооны** үнэлгээтэй байна.

№	Засгийн газрын гишүүн	Үнэлгээ	Төрийн захиргааны төв байгууллагат хүргүүлсэн огноо
1	Монгол Улсын ерөнхий сайдтай байгуулсан батламж	100.0% 5.00 оноо	2017.12.28-ны өдрийн 1-2324 дугаар албан бичиг
2	Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	100.0% буюу 5.00 оноо	2017.12.18-ны өдрийн 1-2486 дугаар албан бичиг
3	Монгол Улсын шадар сайд	100.0% буюу 5.00 оноо	2017.12.21-ны өдрийн 1-2486 дугаар албан бичиг
4	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	96.39% буюу 4.82 оноо	2017.12.18-ны өдрийн 1-2432
5	Батлан хамгаалахын сайд	100.0% буюу 5.00 оноо	2017.12.12-ны өдрийн 1-2377 дугаар албан бичиг
6	Сангийн сайд	100.0% буюу 5.00 оноо	2017.12.15-ны өдрийн 1-2411 дугаар албан бичиг
7	Хууль зүй дотоод хэргийн сайд	96.39% буюу 4.82 оноо	2017.12.08-ны өдрийн 4-2359 дугаар албан бичиг
8	Хөдөлмөр нийгмийн хамгааллын Сайд	98.92% буюу 4.84 оноо	2017.12.18-ны өдрийн 1-2433 дугаар албан бичиг
9	Барилга, хот байгуулалтын сайд	95.59% буюу 4.94 оноо	2017.12.18-ны өдрийн 1-2429
10	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	99.44% буюу 4.97 оноо	2017.12.25-ны өдрийн 1-2504 дугаар албан бичиг
11	Зам, тээвэр хөгжлийн сайд	93.15% буюу 4.66 оноо	2017.12.15-ны өдрийн 1-2416 дугаар албан бичиг
12	Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайд	100.0% буюу 5.00 оноо	2017.12.14-ны өдрийн 1-2399 дугаар албан бичиг
13	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	95.08% буюу 4.75 оноо	2017.12.18-ны өдрийн 1-2430 дугаар албан бичиг
14	Эрчим хүчний Сайд	100.0% буюу 5.00 оноо	2017.12.12-ны өдрийн 1-2376 дугаар албан бичиг
15	Эрүүл мэндийн сайд	99.5% буюу 4.98 оноо	2018.01.09-ний өдрийн 1-10/27 дугаар албан бичиг
<b>Дундаж үнэлгээ</b>		<b>98.40% буюу 4.92 оноо</b>	

## **2. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ҮНЭЛГЭЭ**

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2017 оны төлөвлөгөөний 2 зорилт, 15 арга хэмжээний хэрэгжилт **100.0%** буюу **5.0 оноо-р** үнэлэгдсэн.

Тайлангийн дэлгэрэнгүй мэдээлэл (**Хавсралт-10**-ыг үзнэ үү)

Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын “Хүний нөөцийг чадавхижуулах, тогтворт суурьшилтай ажиллуулах талаар 2017 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан 2 зорилтын 5 үйл ажиллагааны 10 шалгуур үзүүлэлтийн биелэлтийн дундаж үнэлгээ **100.0%** буюу **5.0 оноо-оор** үнэлэгдсэн.

Тайлангийн дэлгэрэнгүй мэдээлэл (**Хавсралт-11**-ийг үзнэ үү)

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

**2018.03.20**

## 1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын “Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт”-ийг “Үйл ажиллагааны ил тод байдал” бүлгийн 9 шалгуур үзүүлэлт, “Хүний нөөцийн ил тод байдал” бүлгийн 5 шалгуур үзүүлэлт, нийт 14 үзүүлэлтийн хэрэгжилт **100.0%** буюу **5.0 оноо**-р үнэлэгдсэн.

Тайлангийн дэлгэрэнгүй мэдээлэл (**Хавсралт-12**-ыг үзнэ үү)

2017 онд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 15,156.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 136 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг 100 хувийн гүйцэтгэлтэй **1,249.5** сая төгрөгийн хэмнэлттэй, үр ашигтай зохион байгуулсан.

Тайлангийн дэлгэрэнгүй мэдээлэл (**Хавсралт-13**-ыг үзнэ үү)

Аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газраас хэрэгжүүлж буй үйл

ажиллагаануудын талаар тогтмол мэдээлэл, нэвтрүүлгийг хийж ажилласан байна.

Үүнд:

1. “Нээлттэй төр” нэвтрүүлэг-4 удаа,
2. “Сэтгүүлчийн цаг” -4 удаа,
3. “Тамгын газрын цаг”-26 удаа,
4. “Төр, нийгмийн түншлэл”-4 удаа,
5. “Зочны ярилцлага”-12 удаа,
6. “Онлайн шууд дамжуулалт”-2 удаа,
7. “Телевизийн шууд дамжуулалт”-1 удаа.

2017 онд аймгийн ЗДТГ-ын [darkhan.gov.mn](http://darkhan.gov.mn) цахим хуудсаар иргэдийг мэдээллээр ил тод хангах байдлыг хангаж ажилласны үр дүнд 91 999 хандалт бүртгэгдсэн. 170 удаагийн үгэн зарыг аймгийн иргэддээ хүргэсэн.

“Дархан хот” FB аккаунт нь 4977, хуудас нь 11 084, “Дарханы мэдээ” сонин 4186 дагагчтай ба аймгийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 1630 удаагийн зурагт мэдээг мэдээг байршуулж, 765 дүрст мэдээг бэлтгэж, иргэдэд нээлттэй хүргэсэн.

Аймгийн цахим хуудсанд төрийн 26 байгууллагын цахим хуудсыг холбон аймгийн ЗДТГ-аас явуулж байгаа бүх төрлийн ажил үйлчилгээ, үйл явдлын талаарх мэдээлэл, танилцуулга бусад материалыг олон нийтэд хүргэж ажиллалаа.

Мэдээлэл технологийн албанаас эрхлэн гаргадаг “Дарханы мэдээ” сонинг 2017 онд 36 000 ширхэгийг үнэгүй тарааж олны хүртээл болгосон ба “Дархан-Уул аймгийн Засаг даргын 200 хоног”, “Дархан-Уул аймгийн Засаг даргын 300 хоног” сэтгүүлийг нийт 11500 ширхэг хэвлэж, айл өрхүүдэд хүргэж, үйл ажиллагаагаа сурталчилж ажилласан.

## 2. ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Дархан-Уул аймгийн төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2017 оны жилийн эцсийн байдлаар **98.81%** буюу **4.94 онооны** үнэлгээтэй байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар төсвийн 101 байгууллага, Засгийн газрын тусгай сан, бусад сангийн 12 байгууллага, ТӨХК, ТӨААН, ТӨҮГ, ТӨХХК, ТӨ-т их дээд сургууль, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж 16 байгууллага, хувийн аж ахуйн нэгж, төсвөөс татаас авдаг хувийн сургууль эцэцрлэг, өрхийн эрүүл мэндийн төв, эмийн эргэлтийн сангийн 37 байгууллага, нийт 166 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ оруулсан байна.

Эдгээр 166 байгууллага нийт 18468 мэдээлэл оруулахаас 166 байгууллага 18249 мэдээлэл оруулсан буюу 98.81% гүйцэтгэлтэй. Шилэн дансны цахим сүлжээнд мэдээлэл байршуулж буй байгууллагууд нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар цахим сүлжээнд тайлан илгээх үүрэгтэй бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 85 байгууллага уг тайланг илгээхээс 97.64% буюу 83 байгууллага илгээсэн байна.

Тайлангийн дэлгэрэнгүй мэдээлэл (**Хавсралт-14-ийг үзнэ үү**)

#### **4.ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ**

Дэлхийн банк, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хамтран хэрэгжүүлж байгаа "**Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх**" төслийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмыг бодит ажил болгох үүднээс "Хэрэглэгчийн үнэлгээ"-г нэгдсэн нэг аргачлалаар үнэлэх зорилгоор Монгол Улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлээс Дархан-Уул аймаг, Булган аймгийг сонгон авч, "Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа"-ны туршилтыг ЗГХЭГ, Дэлхийн банкны зөвлөхийн удирдлагад дор явуулсан. Уг туршилтын ажил сайн болсон гэж Дэлхийн банкны зөвлөх үнэлж үзээд, судалгааны дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд таницуулсан. Цаашид уг судалгааны дүн бусад аймгуудын хувьд жишиг загвар болох бөгөөд ЗГХЭГ-ын даргын 2017 оны 302 дугаар тушааалаар "Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж"-ийг баталсан, мөн ЗГХЭГ-аас 2017.12.27-ны өдөр "**Иргэдийн оролцоо-нийгмийн эгэх хариуцлага**" санаачилгын үр дүн, сайн туршлагыг танилцуулах "ЦАХИМ ХУРАЛ"-ын зохион байгуулж, уг хуралд "**Иргэдийн сэтгэл ханамж**" судалгааны дүнгийн талаар аймгийн ЗДТГ-ын дарга дэлгэрэнгүй мэдээлэл хийсэн.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагууд жил бүр "Хэрэглэгчийн үнэлгээ"-г хөндлөнгийн байгууллагаар хийлгэх шаардлагатай байдаг. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Засгийн газрын ахлах референт Л.Цэнджав, Дэлхийн банкны МАСАМ төслийн зөвлөх Л.Булган нар манай аймагт ажиллаж, техник арга зүйн туслалцаа үзүүлж, 2017 оны 10, 11 дүгээр сард 2 удаагийн сургалт зохион байгуулж, ажлын хэсэг болон судалгаа хийх байгууллагын судалгааны баг бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсон.

Энэ хүрээнд аймгийн ЗДТГ-ын даргын 2017.10.04-ны өдрийн А/42 дугаар тушаалаар "Хэрэглэгчийн үнэлгээ"-г хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үр дүнг тайлагнах, мэдээлэх чиг үүрэг бүхий ХШУДАХ-ийн даргаар ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй "Ажлын хэсэг" байгуулагдан, 20 арга хэмжээ тусгагдсан ажлын хэсгийн төлөвлөгөө, "Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс санал асуулга авах ажлын УДИРДАМЖ"-ыг тус тус боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Мөн "Хэрэглэгчийн үнэлгээ"-г зохион явуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг 4 ТББ-ын дунд явуулж, МҮХАҮТ-ын Дархан салбар шалгарч, "**Иргэдийн сэтгэл ханамжийн санал асуулга**"<sup>7</sup>-ын судалгааг Дархан-Уул аймгийн 4 сумын 26 багийн хэмжээнд түүвэрлэлтийн аргаар 1000 иргэдийн дунд явуулсан байна.

<sup>7</sup> "Иргэдийн сэтгэл ханамжийн санал асуулга" нь 3 бүлэг, 32 асуулт бүхий үйл ажиллагааны 12 үндсэн чиглэлээр 66 үзүүлэлт, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар 21 үзүүлэлт, нийт 87 үзүүлэлтийг агуултуудас бүрдсэн бүтэцтэй.

Ажлын хэсгийн хувьд нутгийн захиргааны байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс санал асуулга авах ажлын удирдамж, иргэдийн сэтгэл ханамжийн санал асуулгын хуудас зэргийг боловсруулсан бөгөөд хөндлөнгийн байгууллагаар "Хэрэглэгчийн үнэлгээ"-г хийх ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, явцад хяналтыг тавин ажиллалаа.

### **Судалгааны зорилго:**

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй, шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийж, цаашид өөрчлөх бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

### **Судалгааны үр дүн<sup>8</sup>**

Судалгаанд оролцогчдын 60.22% буюу 598 иргэн нь 25-44 насны иргэд байсан бол 22.76% буюу 226 иргэн нь өрхийн амьжиргаа дээшилсэн, 547 иргэн буюу 55.09% нь амьжиргаа хэвийн түвшинд байна гэсэн дүн гарсан байна.

Судалгааны дүнгээр 362 иргэн буюу 36.2% нь төрийн байгууллагын төрийн албан хаагчийн мэдээлэл бүрэн нээлттэй, 501 иргэн буюу 50.1% нь мэдээлэл боломжийн гэсэн хариултыг өгсөн байна.

Судалгааны дүнгээр дэд бүтэц, эрүүл орчин, эрүүл мэнд, боловсрол, нийтийн тээвэр, хүнс, хөдөө аж ахуй зэрэг салбаруудын үйл ажиллагаанд 50.0-54.0%-ийн үнэлгээ өгсөн бол төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар 54.4%-ийн үнэлгээний дүнтэй байна.

Судалгааны олон асуулга дээр иргэд "Мэдэхгүй" гэсэн хариулт өгсөн нь салбар, салбариин чиглэлээр иргэдийн мэдлэг хангалтгүй, мэдээлэл дутмаг байгааг харуулсан төдийгүй судалгааны үр дүнд их бага хэмжээгээр нөлөөлснийг дурдах нь зүйтэй гэж судалгаа хийсэн байгууллага дүгнэсэн байна.

### **ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

#### **"Судалгааны баг"-ийн зүгээс:**

Хэрэглэгчийн үнэлгээний мэдээлэл цуглуулах, дүгнэх явцад анхаарал татсан болон иргэдээс гарсан саналуудыг товч дурьдвал:

- ✓ Аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын ажил хангалтай түвшинд хийгдсэн сайшаалтай хэдий ч хайрлах хамгаалах тал дээр иргэдийн сэтгэл, мэдлэг боловсрол дутаж байгаад анхаарах;

---

<sup>8</sup> Дэлхийн банк, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хамтран хэрэгжүүлж байгаа "Иргэдийн оролцоо-нийгийн эгэх хариуцлага" санаачлагын үр дүн, сайн туршлагыг танилцуулах "ЦАХИМ ХУРАЛ" 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 10 цагт аймгийн Засаг даргын Тамгын газар болсон.

- ✓ Судалгааны явцад иргэдийг бухимдуулдаг ямар асуудлууд байгааг олж харсан нь цаашид юунд, ямар асуудалд анхаарах талаар бодит ойлголттой болсон, **Тухайлбал**, цахилгааныг урьдчилж хэлэхгүй тасалдаг, цалин буугаагүй үетэй нь давхцуулж төлбөр нэхдэг гэх мэт;
- ✓ Гэр хорооллыг иргэдийн зүгээс цахилгааны шөнийн тарифтай болоход дэмжлэг үзүүлэх;
- ✓ Хот доторх гэрэлтүүлэг, хүүхдийн тоглоомын талбай, худаг усны тоог нэмэгдүүлэх;
- ✓ СӨХ-үүдийн үйл ажиллагааг сайжруулах, автомашины зам засварын ажлыг чанартай хийх;

**“Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаан”-аас болон “Ажлын хэсэг”-ийн зүгээс: **Анхаарах асуудлууд****

- Судалгааны ажлыг мэргэжлийн түвшинд хийдэг, туршлагатай байгууллагыг сонгох, ялангуяа хүний нөөцийн чадавхи, мэдлэг, ур чадвар маш чухал гэдгийг онцлон анхаарах, чадавхижуулах, судалгаа хийх талаар мэргэшүүлэх, /Дэлхийн банкны зөвлөх бидний адил саналтай байсан/
- Судалгааг бодитой хийхийн тулд тухайн онд хийгдсэн ажлын талаар үнэн бодит мэдээллийг иргэдэд өгөх, судалгаанд оролцогч иргэдтэй зөв харьцах, зөв ойлгуулах, зөв тайлбарлах,
- Судалгааны ажлыг явуулахдаа тухайн цаг үе маш чухал, **Тухайлбал**, иргэдийн оролцоотой бүтээн байгуулалтын ажил хийсэн үед нэг өөр, цаг хугацаа нь тохиромжтой биш үед хийсэн бүтээн байгуулалтын ажил иргэдийг маш их бухимдуулж байгаа, жишээ нь: манай аймагт 10,11-р сард Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дулааны шугам сүлжээний шинэчлэлтийн ажил иргэдийг маш их бухимдуулсан нь иргэдийн санал асуулгад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн,
- Уул уурхай, гааль зэрэг зарим салбарын талаар иргэд бодит ойлголт, мэдлэг байхгүй учраас **“Мэдэхгүй”** гэсэн хариулт өгсөн нь судалгааны дүнд их, бага хэмжээгээр нөлөөлсөн,
- Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллага, оюутнууд, судлаачид, Олон улсын байгууллагуудын мэргэжилтнүүд янз бүрийн чиглэлээр олон төрлийн олон янзын судалгаа авдаг, зарим нь мөнгө төлж авдаг зэрэг нь иргэдээс судалгаа авахад залхсан, дургүйцдэг, мөнгө нэхдэг, асуултыг сэтгэл гаргаж зөв бөглөдөггүй байдал ажиглагдсан,
- Иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах, **Тухайлбал**, “Хэрэглэгчийн үнэлгээ”-ний судалгааны дүнгээр ажлаа дүгнүүлэх нь чухал биш, бидний өмнө тулгамдаж буй шийдвэрлэх асуудлуудыг гаргаж ирэх, Дархан хотоо хөгжүүлэхэд иргэн Таны үнэтэй санал, оролцоо чухал гэдгийг ойлгуулах, бид ямар алдаа дутагдал гаргасан бэ, ямар оолот, амжилт бүтээлтэй ажилласан бэ цаашид юу хийх вэ, бидний хамтын

ажиллагаанд иргэн Таны оролцоо чухал гэдгийг ойлгуулах, хандлагыг өөрчлөхөд онцгой анхаарах,

- Иргэдээс санал асуулгыг аваадаа “Чанарын арга”-ыг хэрэглэх нь маш чухал гэдэг нь харагдсан, Тухайлбал, иргэдтэй уулзаж, дотно яриа өрнүүлээд ирэхээр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж байх жишээтэй,
- Судалгааны үр дүнгээр гарсан “Санал, Зөвлөмж”-ийг үндэслэн нарийвчилсан “Үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө”-г боловсруулж хэрэгжүүлэх, иргэдээс гарсан саналыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах, тухай санал гаргасан иргэнд эргэж мэдээлэх зэрэг эргэх холбоотой ажиллах,
- Орон сууцны хорооллын байр бүрт 10-15 иргэнийг төлөөлсөн “Хэсгийн ахлагч”-тай “Чанарын арга”-ыг ашиглан нүүр тулан ярилцлага хийх, зөв ойлголт өгөх, хамтран ажиллах санал тавих зэрэг энгийн аргыг ашиглах:
- Иргэдээс санал асуулгыг аваадаа салбар, салбараар нь зөв голдрилоор явуулах, судалгааг зөв хийх, Тухайлбал:
  - a) Эрүүл мэндийн салбарын хувьд Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эмнэлэг, амбулаториор үйлчлүүлж байгаа иргэдээс улирлын чанартайгаар судалгаа авах,
  - b) Бүтээн байгуулалтын ажил хийж дууссаны дараа тухайн сум, баг, хорооллын оршин суугч иргэдээс судалгаа авах,
  - c) Уул уурхай, гаалийн салбарын хувьд тухайн салбараас үр шимийг нь хүртэж байгаа иргэдээс судалгаа авах,
  - d) Тухайн салбар, салбарын онцлогыг харгалзан үйлчлүүлж байгаа иргэдээс судалгаа авах нь илүү бодитой, үр дүнтэй байх болно.

## Ололт амжилтууд

- Аймгийн ЗДТГазрын хэрэгжүүлж байгаа Олон улсын ISO 9001:2015 стандартын эцсийн үр дүн “Иргэдийн сэтгэл ханамж” бөгөөд бидний хувьд “Хэрэглэгчийн үнэлгээ” хийх боломжийн туршлагатай болсон, Төрийн бус байгууллага нь судалгаа шинжилгээний ажил хийх арга барил, арга зүйд суралцсан, нэгдсэн нэг аргачлалтай болсон, цаашид бид улам сайжруулаад явах боломжтой,
- Аймгийн Засаг дарга тэргүүтэй Удирдлагууд иргэдтэй уулзалт хийж, тэдний санаа бодлыг сонсож, хүсэлтийг хүлээн аваад судалгаанд үндэслэн үйл ажиллагаагаа төлөвлөж, хэрэгжилтийг хангулан ажиллаж байна, **Тухайлбал**, 2017 онд иргэд, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор 300.0 сая төгрөгийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь иргэдийн сэтгэлд нийцсэн бодит ажил болсон.
- Судалгааны үр дүнгээр иргэд юу хүсэж байгаа вэ, бид ирээдүйд яаж хөгжих вэ, юун дээрээ анхаарах вэ, цаашид ямар бодлого, хөтөлбөрөө боловсруулах вэ гэдгээ болон мөн алдаа оноогоо олж харсан, цаашид суурь судалгаа болгон ашиглах боломжтой,
- 2018 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтуудад хэрэглэгчийн үнэлгээний судалгаагаар иргэдээс гарсан саналуудыг бүрэн

тусгаж, судалгаанд үндэслэн үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна. Тухайлбал, “**2018 онд бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааны өрөнхий төлөвлөгөө**”-нд нийт **60 гаруй төсөл арга хэмжээнд 7,2 тэрбум** төгрөгийг төсөвлөж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Дархан сумын 9, 10, 12-р багт 51 ш гэрэлтүүлгийн ажил, 90.0 сая төгрөгийн санхүүжилтээр 7 багийн хэмжээнд 125 автомашины зогсоол шинээр хийх, 150.0 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжих “Миний гэр-Манай байр” төсөл гэх мэт,

- Иргэдийнхээ мэдлэг боловсролыг дээшлүүлэх, нийгмийн хариуцлагыг ухамсарлуулах чиглэлээр дорвитой ажил зохион байгуулах, манай аймгийн хувьд “Хотын дүрэм”-ийг шинээр боловсруулах ажил хийгдэж байна, мөн судалгааны ажил хийгдэж байна,
- Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх чиглэлээр **Төрийн байгууллага-3, төрийн бус байгууллага-2, нийт 5 мэргэжилтэн** бэлтгэгдсэн. Цаашид бид сургалт явуулах боломжтой, бэлтгэгдсэн хүний нөөцтэй болсон.

#### 2017 онд хийсэн ажлууд /Иргэдийн сэтгэлд нийцсэн/

- Цэцэрлэгийн засвар, өргөтгөлийн ажил – 292 иргэн, 29.2%
- Жишиг хороолол төсөл – 149 иргэн, 14.9%
- Гэрэлтүүлэгийн ажил – 140 иргэн, 14.0%
- “Миний гэр – Манай байр” хөтөлбөр – 89 иргэн, 8.9%
- Ахмад настанд үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээ – 83 иргэн, 8.3%%

“Хэрэглэгчийн үнэлгээ” хийсэн судалгаагаар иргэдээс гарсан саналыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд иргэдээс гарсан 49 саналыг багцлан эрэмбэлэн боловсруулан тусгаж, аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулж, 2018 оны аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр дэс дараалалтай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд тусгагдсан саналууд бодитой хэрэгжих боломжтой юм.

Орон нутгийн төсөв: **2017 онд 4.2 сая төгрөгөөр санхүүжүүлж, 2018 онд 5.6 сая төгрөгийг** Орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт тусгаж ажиллалаа.

(Дэлгэрэнгүй тайлан, “Хэрэглэгчийн үнэлгээ хийсэн судалгаагаар иргэдээс гарсан саналыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г аймгийн Засаг даргын 2018.02.12-ны өдрийн 1-10/103 дугаар албан бичгийн хавсралтаар ЗГХЭГ-ын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлэв.)

Дархан-Уул аймгийн “Нэг цонхны үйлчилгээний 2017 оны үйл ажиллагааны тайлан”-гийн дэлгэрэнгүй мэдээлэл (**Хавсралт-15-ыг үзнэ үү**)

#### **ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДЛУУД:**

1. Дархан-Уул аймгийн Хонгор сум нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумтай хиллэсэн хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх,
  2. Дархан сумын 15 дугаар багийн үерийн даланг шинээр байгуулахад / 1.5 тэрбум/,
  3. Дархан-Шарын гол чиглэлийн 47.79 км сайжруулсан шороон замыг хатуу хучилттай болгох / Кувейт улсын хөрөнгө оруулалтаар- 32.7 сая/,
  4. Шинэ хуучин Дарханыг холбосон 5.7 км хатуу хучилттай автозам барих /12.0 тэрбум төг/,
  5. Хонгор- Салхит өртөөний 13.1 км замыг хатуу хучилттай автозам барих /3.2 тэрбум төг/,
  6. Малын удмын сангийн цогцолбор байгуулагдсантай холбогдуулан “Эрчимжсэн мал аж ахуйн сууршлын бус шинээр байгуулах,
  7. Үйлдвэр технологийн паркийн хууль эрх зүйн орчин, дэд бүтэц шийдэгдсэн тул “Арьс ширний үйлдвэр бусад боловсруулах үйлдвэрийг байгуулахад дэмжлэг үзүүлэх,
  8. Их дээд мэргэжлийн сургуулиудыг Дархан-Уул аймагт төвлөрүүлэхэд бодлого зохицуулалтаар дэмжих,
  9. Ерөнхий боловсролын эко сургууль шинээр барьж байгуулах,
  - 10.Дархан-уул аймгийн Дархан сумын 10 багийн нутаг дэвсгэр дэх Нийгмийн даатгалын хэлтсийн байрлаж байсан барилгыг цэцэрлэгийн зориулалтаар шийдвэр гаргах,

## ТАНИЛЦСАН:

# ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

**ХЯНАСАН:**  
**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА**                                   **Д.ЖАРГАЛСАЙХАН**

**ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН**

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**  
(2017 он)

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	98.30	0.6	58.28
	2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	96.13		
	3. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	98.46		
	4. Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	95.66		
	5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	97.16		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Засгийн Газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	98.40	0.2	19.84
	2. Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	100.0		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100.0	0.2	19.92
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	98.81		
	3. Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ <sup>9</sup>	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	50.9 <sup>10</sup>		
Ерөнхий үнэлгээ:		98.04	1.0	98.04

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗДТГ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

<sup>9</sup> Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн дагуу АТГ-ын даргын 2010 оны 59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлж дүгнэдэг. 2017 онд судалгааг шинжээч, төрийн албан хаагчид, Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болон иргэд зэрэг нийт 70 хүнээс судалгаа авсан болно.

<sup>10</sup> Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 9.7, 9.8 дахь заалтыг үндэслэн хэрэглэгчийн үнэлгээ буюу сэтгэл ханамжийн судалгааг ЗГХЭГазар, Дэлхийн банкны зөвлөхтэй хамтран туршилтын судалгааг Дархан-Уул аймагт 2017 оны 12 дугаар сард хийж, судалгааны тайлан болон тайлангийн дүн шинжилгээг ЗГХЭГ-ын ХШУДАГ-т 2018.02.12-ны өдрийн 1-10/103 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

